



ӨМНӨГОВЬ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

АУДИТЫН НЭР: ТӨРӨӨС БҮХ НИЙТИЙН БОЛОВСРОЛ
ОЛГОЖ БУЙ ӨНӨӨГИЙН БАЙДАЛ, ҮР ДҮН

АУДИТЫН КОД: /ӨМА-2020/03/-ГА



**СУМДЫН СУРГУУЛИУДЫН СУРГАЛТЫН ЧАНАРЫН ЯЛГААГ
АРИЛГАХ ШААРДЛАГАТАЙ БАЙНА.**

2020 ОН

	АГУУЛГА	Хуудас
Аудитыг гүйцэтгэсэн:	Товчилсон үгийн тайлбар	3
Өмнөговь аймаг дахь Төрийн аудитын газрын дарга бөгөөд тэргүүлэх аудиторовын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Т.Хонгорзул	Хүснэгт, зурган мэдээллийн жагсаалт	4
Хэлтсийн дарга бөгөөд аудитын менежерын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч С.Одончимэг	Аудитын зорилт, арга зүй, стандартын талаарх мэдэгдэл	5-6
Аудитор: Ш.Отгонбаяр Ч.Наранбадрах	Бүлэг 1. Үдийн цайны төсөв, түрээсийн сурах бичиг олгох журам, сумдын ЕБС-иудын багш нарын ажлын нормыг хэрэгцээ шаардлагад нийцүүлэн шинэчлэх шаардлагатай байна.	
Гэрээт ажилтан: Б.Ууганбаяр	А.1 Эрх зүйг зохицуулалтын дагуу бодлого, хөтөлбөрийг хэрэгцээ шаардлагад нийцүүлэн шинэчлэн баталсан байна.	
	А.2 Аймгийн төв болон сумдын багш боловсон хүчний тэгш хүртээмжтэй байдлыг сайжруулж сургалтын чанарын ялгааг арилгах шаардлагатай байна.	6-15
	А.3 ЕБС –ийн үдийн цайны төсөв хуваарилах зарчим, ном сурах бичиг түрээслэх үйл ажиллагааг зохицуулсан журмыг хэрэгцээ шаардлагад нийцүүлэн шинэчлэх шаардлагатай байна.	
2020 оны 10 дугаар сар	Бүлэг 2. ЕБС-удын дотоод хөндлөнгийн хяналт хийх арга зүйг сайжруулж, тэгш хүртээмжтэй бодлого хэрэгжүүлэх шаардлагатай байна	
Аудитын тайлан, дүгнэлттэй холбоотой асуудлаар нэмж тодруулах, асууж лавлах зүйл байвал 70533539, 70533552 дугаарын утсаар харилцана уу.	Б.1 Ерөнхий боловсрол олгох хөтөлбөрийг тэгш хүртээмжтэй хүргэж, сурагчдын үр дүнгийн үнэлгээг бодитой хийх шаардлагатай байна.	16-20
Тайланг МТАГ-ын www.umnugovi@audit.gov.mn цахим хуудаснаас үзнэ үү.	Б.2 ЕБС-удад хийх доотоод хөндлөнгийн үнэлгээ, хяналт шинжилгээ хийх арга зүйг сайжруулах шаардлагатай байна.	
Хаяг: Нутгийн удирдлагын ордон, 3 давхар, 303 тоот	Дүгнэлт	21
	Зөвлөмж	22
	ҮАГ-т хүргүүлэх санал	23
	Тэргүүлэх аудиторовын тушаал	24

ТОВЧИЛСОН ҮГИЙН ТАЙЛБАР

АДБОУС	Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт
УИХ	Улсын Их Хурал
ЗДТГ	Засаг даргын тамгын газар
ИТХ	Иргэдийн төлөөлөгчдийн хурал
МХГ	Мэргэжлийн хяналтын газар
БСУГ	Боловсрол
ТАХ	Төсөл арга хэмжээ
ЭЕШ	Элсэлтийн ерөнхий шалгалт
ЗДҮАХ	Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөр
ЭЗНХ	Эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх
ОНХА	Олон нийттэй харилцах алба
БҮТ	Боловсролын үнэлгээний төв
БСШУС	Боловсрол, соёл, шинжлэх ухааны сайд
НХХС	Нийгмийн хамгаалал, хөдөлмөрийн сайд
ОНХС	Орон нутгийн хөгжлийн сан

ХҮСНЭГТ, ЗУРГАН МЭДЭЭЛЛИЙН ЖАГСААЛТ

Хүснэгт № 1. 2016-2019 оны хичээлийн жилийн ЕБС-ын мэдээлэл	5
Хүснэгт № 2. Өмнөговь аймгийн боловсролын салбарыг хөгжүүлэх дэд хөтөлбөр	6
Хүснэгт № 3. Аймгийн ЗДҮАХ-ийг хэрэгжүүлэх ТАХ.....	7
Хүснэгт № 4. ЗДҮАХ-ийн зорилт давхардсан дэд хөтөлбөр болон төсөл арга хэмжээ..	7
Хүснэгт № 5. 2016-2019 оны хичээлийн жилийн анги дүүргэлт	9
Хүснэгт № 6. 9-р ангийн чанарын үнэлгээний тойм статистик.....	10
Хүснэгт № 7. Нэмэлт хичээл заадаг багш нарын судалгаа / 2016-2019 он/	13
Хүснэгт № 9. Үдийн цай хөтөлбөрийн төсөв /2016-2019 он/	14
Хүснэгт № 8. Түрээсийн сурах бичгийн олголт.....	15
Хүснэгт № 10. Сурагчдын үр дүнгийн үнэлгээний өсөлт, бууралт (2016-2019 он)	16
Хүснэгт № 11. Өмнөговь аймгийн ЭЕШ-ын дүн /2017-2020 он/.....	17

Зураг № 1. Өмнөговь аймгийн ЕБС-удын зөвлөлийн гишүүдийн бүтэц	6
Зураг № 2. Аймгийн ИТХ-ын хэрэгжүүлсэн арга хэмжээ /2016-2019 он/	8
Зураг № 3. Сургуулиудын чанарын дундаж үнэлгээ болон сурагчийн тооны хамаарал	10
Зураг № 4. Манлай сумын ЕБС-ын шинэ барилга	10
Зураг № 5. Номгон сумын ЕБС-ын шинэ барилга.....	10
Зураг № 6. Даланзадгад сумын 1200 хүүхдийн.....	11
Зураг № 7. Ханбогд сумын ЕБС-ийн шинэ барилга	11
Зураг № 8. ЕБС-ын албан тушаал, орон тооны харьцаа	12
Зураг № 9. 2016-2019 оны хичээлийн жилийн мэргэшлийн зэрэгтэй багш нарын тоо.	12
Зураг № 10. Багш нарын боловсролын зэрэг / 2016-2019он/.....	12
Зураг № 11. Багш нарын байршил аймгийн төв, сумдаар	12
Зураг № 12. Даланзадгад сумын 5-р сургуулийн үдийн цайны цэс	14
Зураг № 13. 2018-2019 оны хичээлийн жилийн чанарын үнэлгээ /9-р анги/	18
Зураг № 14. БҮТ болон сурагчдын үр дүнгийн үнэлгээний зөрүү /2018-2019 оны хичээлийн жил/.....	18
Зураг № 15. "School police" хөтөлбөрийн үйл ажиллагаа.....	18
Зураг № 16. "School police" хөтөлбөрийн үйл ажиллагаа.....	18

АУДИТЫН ЗОРИЛТ, АРГА ЗҮЙ, ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТ

Аудит хийх үндэслэл, бүрэн эрх

“Аудитын төлөвлөгөө батлах тухай” Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2019 оны А/100 дугаар тушаалын дагуу Төрийн аудитын тухай хуулиар тодорхойлсон орон нутаг дахь Төрийн аудитын газрын бүрэн эрхийн хүрээнд хийлээ.

Аудитын зорилт

Төрөөс бүх нийтийн боловсрол олгож буй өнөөгийн байдал, үр дүнд аудит хийж, дүгнэлт, зөвлөмж боловсруулж УИХ, холбогдох байгууллага, албан тушаалтанд танилцуулж, олон нийтэд мэдээлэхэд чиглэсэн аудитын зорилгын хүрээнд дараах чиглэлээр аудитыг гүйцэтгэлээ.

Үүнд:

- ✓ Ерөнхий боловсрол олгож буй өнөөгийн нөхцөл хэрэгцээ шаардлагад нийцэж байгаа эсэх;
- ✓ Ерөнхий боловсрол олгох үйлчилгээний зорилго, зорилт хангагдаж байгаа эсэх;

Аудитын хамарсан хүрээ

Аудитаар аймгийн ИТХ, ЗДТГ, БСУГ, МХГ болон Төрийн өмчийн 22 ерөнхий боловсролын сургуулийн 2016-2019 оны хичээлийн жилийн үйл ажиллагааг хамрууллаа.

Аудитын арга зүй

Аудитыг гүйцэтгэхэд Гүйцэтгэлийн аудитын удирдамж (АДБОУС-300, 3000-3100), Монгол Улсын төрийн аудитын стандарт, Гүйцэтгэлийн аудитын журмыг ашигласан бөгөөд холбогдох албан тушаалтнуудтай ярилцлага хийх, асуулга лавлагаа болон судалгаа авах, тулган баталгаажуулах, нэгтгэн дүн шинжилгээ хийх аудитын горимыг хэрэгжүүлж, арга зүйн дагуу нотлох баримтыг цуглуулж аудитын дүгнэлт, зөвлөмж боловсруулав.

Аудитад ашигласан шалгуур үзүүлэлт

Аудитад дараах хууль, эрх зүйн актыг шалгуур болгон ашигласан. Үүнд:

- ✓ Боловсролын тухай хууль,
- ✓ Бага, дунд боловсролын тухай хууль,
- ✓ Багшийн хөгжлийн тухай хууль, Төсвийн тухай хууль,
- ✓ Багшийн хөгжлийг дэмжих тухай хууль,
- ✓ УИХ-ын 2015 оны 12 дугаар тогтоолоор баталсан “Төрөөс боловсролын талаар баримтлах 2014-2024 оны бодлого”
- ✓ УИХ-ын 2016 оны 19 дүгээр тогтоолоор баталсан “Монгол Улсын тогтвортой хөгжлийн үзэл баримтлал - 2030”,

Аудитын хугацаа

Хүндрэл, бэрхшээл

- ✓ УИХ-ын 2016 оны 19 дүгээр тогтоолоор баталсан “Монгол Улсын Засгийн газрын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөр”
- ✓ Аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн 2015 оны 165 тогтоол,
- ✓ Аймгийн ИТХ 2016 оны 2/2 тогтоолоор баталсан “Өмнөговь аймгийг 2016-2020 он хүртэл хөгжүүлэх аймгийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөр”
- ✓ Бусад хууль, эрх зүйн актууд

Аудитыг 2020 оны 09 дүгээр сарын 02-ны өдрөөс 2020 оны 10 дугаар сарын 19-ны өдөр хүртэл хугацаанд хэрэгжүүлэв.

Аудитын явцад орон нутгийн сонгууль болон бусад шалтгааны улмаас 8 сургууль захирлын үүргийг түр орлон гүйцэтгэгч хариуцдаг, зарим ажил хариуцсан мэргэжилтэн шилжсэн, солигдсон, сумдын сургуулиуд И-Оффис системийн ашиглалтын байдал хангалтгүй байсан зэргээс шалтгаалан судалгаа мэдээлэлээ бүрэн ирүүлэхгүй хугацаа хоцроосон зэрэг нь аудитын талбарын ажил гүйцэтгэхэд хүндрэл учруулсан болно.

Ерөнхий мэдээлэл

Аймгийн ИТХ-ын тэргүүлэгчдийн 2015 оны 165 дугаар тогтоолоор баталсан “Өмнөговь аймгийн боловсролын салбарыг /2015-2018/ хөгжүүлэх, бодлого чиглэл”-тэй уялдуулан аймгийн ИТХ-ын 2016 оны 2/2 тогтоолоор “Өмнөговь аймгийг 2016-2020 он хүртэл хөгжүүлэх аймгийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөр”-т боловсролын салбарыг хөгжүүлэхэд чиглэсэн 13 зорилтыг дэвшүүлэн, 4 дэд хөтөлбөрийг хэрэгжүүлэхээр баталсан байна.

2016-2019 оны хичээлийн жилүүдэд 1 шинэ сургууль ашиглалтанд орж, бүлгийн тоо 1.04, сурагчдын тоо 1.06, багшийн 1.04 дахин өссөн үзүүлэлтэй байна.

Хүснэгт № 1. 2016-2019 оны хичээлийн жилийн ЕБС-ын мэдээлэл

Хичээлийн жил	Сургуулийн тоо	Бүлгийн тоо	Сурагчдын тоо	Багшийн тоо
2016 – 2017 он	20	413	11392	605
2017 – 2018 он	21	429	11796	624
2018 – 2019 он	21	431	12109	634

Эх сурвалж: БСУГ-ын статистик мэдээ /2016-2019он/

Мөн дээрх хугацаанд ЕБС-ийн багшийн чадварыг нэмэгдүүлэх, суралцах орчныг сайжруулах зорилгоор улсын төсвийн 11,536.7 сая төгрөг, орон нутгийн төсвийн 8,898.5 сая төгрөг, “Говийн оюу” хөгжлийг дэмжих сангийн 8,291.5 сая төгрөгийн хөрөнгө оруулалт хийгдсэн байна.

БҮЛЭГ 1


Үдийн цайны төсөв, түрээсийн сурах бичиг олгох журам, сумдын ЕБС-иудын багш нарын ажлын нормыг хэрэгцээ шаардлагад нийцүүлэн шинэчлэх шаардлагатай байна.

А.1 Эрх зүйг зохицуулалтын дагуу бодлого, хөтөлбөрийг хэрэгцээ шаардлагад нийцүүлэн шинэчлэн баталсан байна.

А.1.1 Олон нийтийн тэгш оролцоог хангасан сургуулийн зөвлөл байгууллагын дунд хугацааны бодлогын бичиг баримтыг баталсан байна.

Аймгийн хэмжээнд Боловсролын тухай хуулийн 35.1¹-д заасны дагуу сургуулийн зөвлөлийг байгуулан ажилласан ба нийт гишүүдийн 37 хувь нь багш ажилтны төлөөлөл, 23 хувь нь эцэг, эхийн төлөөлөл, 13 хувь нь сурагчийн төлөөлөл, 27 хувь нь бусад байгууллагын төлөөлөл эзлэн олон талт оролцоог хангасан байна. Харин Гурвантэс, Номгон сумдын сургууль зөвлөл байгуулаагүйд зөвлөл байгуулж ажиллах тухай зөвлөмж хүргүүлээ.

Зураг № 1. Өмнөговь аймгийн ЕБС-удын зөвлөлийн гишүүдийн бүтэц



Эх сурвалж: ЕБС-аас авсан хавсралт судалгаа

Сургуулийн захирал Боловсролын тухай хуулийн 35.4.1²-д заасны дагуу сургуулийн зөвлөлийн баталсан дунд хугацааны стратеги төлөвлөлтийг дагуу жилийн үйл ажиллагааны төлөвлөгөөг салбарын яам, аймгийн бодлого зорилттой уялдуулан төлөвлөж хэрэгжүүлсэн байна.

А.1.2 Ерөнхий боловсрол олгох ажлыг хэрэгцээ шаардлагад нийцсэн бодлого, хөтөлбөртэй уялдуулан төлөвлөж хэрэгжүүлсэн байна.

Аймгийн ИТХ-ын тогтоолоор БСУГ-ын 2015-2016 оны статистик мэдээлэл, 2016 оны ЭЕШ-ын дүн шинжилгээнд үндэслэсэн “Хүүхэд хөгжлийн түлхүүр”, “Оюуны хурд”, “Англи хэлтэй - Өмнөговь”, “Багш хөгжил” хөтөлбөрүүдийг баталж чанартай ерөнхий боловсрол олгох ажлыг эрчимжүүлсэн байна.

Хүснэгт № 2. Өмнөговь аймгийн боловсролын салбарыг хөгжүүлэх дэд хөтөлбөр

№	Дэд хөтөлбөрийн нэр	Аймгийн ИТХ-ын тогтоолын дугаар	Огноо
1	Хүүхэд хөгжлийн түлхүүр	54	2016.11.28

¹ Сургууль, цэцэрлэгийн зөвлөл нь багш, ажилтан, сурагч, эцэг, эх бусад байгууллагын төлөөлөлтэй байна. 9-11 гишүүнтэй сургууль, цэцэрлэгийн зөвлөлийг 3 жилийн хугацаагаар сонгоно

² Сургууль, цэцэрлэгийн хөгжлийн бодлого, хөтөлбөр, төлөвлөгөө, дүрэм, журам батлах, хэрэгжүүлэхэд нь дэмжлэг үзүүлэх

2	Оюуны хурд	55	2016.11.28
3	Багш хөгжил	56	2016.11.28
4	Англи хэлтэй – Өмнөговь	57	2016.11.28

Эх сурвалж: Өмнөговь аймгийн цахим сайт <http://www.omnogovi.gov.mn>; 2020/

Аймгийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрт тусгагдсан ерөнхий боловсролын салбарыг хөгжүүлэх 13 зорилтын хэрэгжүүлэх 50 ТАХ-г 2017-2019 оны аймгийн нийгэм эдийн засгийг хөгжүүлэх үндсэн чиглэлд, дэд хөтөлбөрийг хэрэгжүүлэх жилийн ажлын төлөвлөгөөнд 162 арга хэмжээг тусган баталж хэрэгжүүлж ажилласан байна.

Хүснэгт № 3. Аймгийн ЗДҮАХ-ийг хэрэгжүүлэх ТАХ

ЗДҮАХ- ын дугаар	Дэвшүүлсэн зорилт	ЭЗНХ үндсэн чиглэл		
		2017 ОН	2018 ОН	2019 ОН
1.16	Хүүхдийг монгол ёс заншлаа дээдэлсэн, эх оронч, авъяаслаг, боловсролтой иргэн болгож төлөвшүүлэх “Хүүхэд-хөгжлийн түлхүүр” хөтөлбөрийг хэрэгжүүлнэ.	1	1	1
1.17	Математикийн сургалтын чанарыг сайжруулах “Оюуны хурд” хөтөлбөрийг хэрэгжүүлнэ	1	1	1
1.18	Боловсролын цөм хөтөлбөрийн хэрэгжилтийн хөндлөнгийн үнэлгээг 70 хувьд хүргэн, сургалтын чанарыг дээшлүүлж боловсролын түвшнийг сайжруулна.			1
1.20	Хүүхдийг мэргэжлээ зөв, сонгоход нь дэмжлэг үзүүлэх төрөлжсөн сургалттай клубийг сургуулиудад байгуулна			1
1.21	Сайхан бичигтэн- Өмнөговь уламжлалыг сэргээнэ	1		1
1.22	Багш нарын онолын мэдлэг, ур чадвар, заах аргыг сайжруулах “Багш – Хөгжил” хөтөлбөрийг хэрэгжүүлнэ.	1	1	1
1.23	Даланзадгад сумын сургуулиудад нийтийн тээврийн үйлчилгээг ойртуулж, хүүхдийн аюулгүй зорчих орчин нөхцөлийг сайжруулна	1		
1.24	Хүүхдийн эрүүл, аюулгүй орчныг хангах зорилгоор сургууль, цэцэрлэгийн хоолны газар, биеийн тамирын талбайг тохижуулж, эко орчин бүрдүүлнэ.	4		
1.25	Сургууль цэцэрлэгийн орчин нөхцөлийг сайжруулан, барилга шинээр барих, засвар өргөтгөл хийх, тоног төхөөрөмж, техник хэрэгслээр хангах ажлыг үргэлжлүүлнэ.	6	7	9
1.26	Тусгай хэрэгцээт боловсролыг хөгжүүлж, сургууль, цэцэрлэгт хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн тусгай анги, бүлгийг нээж ажиллуулна.	1	1	1
1.27	Насан туршийн боловсролын үйл ажиллагааны хамрах хүрээг өргөтгөн, чанар хүртээмжийг нэмэгдүүлнэ.			4
1.28	Хүүхэд, залуучуудын гадаад хэлний мэдлэгийг дээшлүүлэх “Англи хэлтэй - Өмнөговь” хөтөлбөрийг хэрэгжүүлнэ.	1	1	1
ЖИЛИЙН ДҮН		17	12	11
НИЙТ ДҮН			50	

Эх сурвалж: 2016-2020 оны аймгийн ЗДҮАХ, 2017-2019 аймгийн ЭЗНХ үндсэн чиглэл

Хүснэгт № 4. ЗДҮАХ-ийн зорилт давхардсан дэд хөтөлбөр болон төсөл арга хэмжээ

ЗДҮАХ- ийн дугаар	Дэвшүүлсэн зорилт	Давхардаж хэрэгжүүлсэн дэд хөтөлбөр
1.18	Боловсролын цөм хөтөлбөрийн хэрэгжилтийн хөндлөнгийн үнэлгээг 70 хувьд хүргэн, сургалтын чанарыг дээшлүүлж боловсролын түвшнийг сайжруулна.	“Багш хөгжил”, “Оюуны хурд”, “Англи хэлтэй - Өмнөговь”

1.20	Хүүхдийг мэргэжлээ зөв, сонгоход нь дэмжлэг үзүүлэх төрөлжсөн сургалттай клубийг сургуулиудад байгуулна	“Хүүхэд хөгжлийн түлхүүр”
1.23	Даланзадгад сумын сургуулиудад нийтийн тээврийн үйлчилгээг ойртуулж, хүүхдийн аюулгүй зорчих орчин нөхцөлийг сайжруулна	ОНХС-аас хэрэгжүүлэх нийтийн тээврийн чанар хүртээмжийг нэмэгдүүлэх ТАХ

Эх сурвалж: 2016-2020 оны аймгийн ЗДҮАХ, 2017-2019 оны дэд хөтөлбөрүүдийг хэрэгжүүлэх төлөвлөгөө болон аймгийн ЭЗНХ үндсэн чиглэл

Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрт тусгасан 3 зорилтыг дэд хөтөлбөрийг хэрэгжүүлэх жилийн ажлын төлөвлөгөөнд оруулж хэрэгжүүлсэн нь дэд хөтөлбөр, үйл ажиллагааны хөтөлбөрийн зорилтууд давхардаж байна.

Аймгийн ЗДҮАХ /2016-2020/-т боловсролын салбарыг хөгжүүлэхээр дэвшүүлсэн зорилт болон дэд хөтөлбөрийн зорилтыг өргөн хүрээнд тодорхойлсон нь тэдгээрийн хоорондын утга санаа давхардах, хэрэгжүүлэх ижил арга хэмжээ төлөвлөх үндэслэл болсон байна. Иймд цаашид нөхцөл байдлын шинжилгээ, дүгнэлтийг оновчтой хийж, тэдгээрийг хэрэгжүүлэх зорилтыг утга санаа давхардуулахгүй төлөвлөх шаардлагатай байна.

А.2 Аймгийн төв болон сумдын багш боловсон хүчний тэгш хүртээмжтэй байдлыг сайжруулж сургалтын чанарын ялгааг арилгах шаардлагатай байна.

А.2.1 Сумдын сургуулийн сургалтын чанарыг сайжруулж, тэгш хүртээмжтэй боловсрол олгох шаардлагатай байна.

Боловсролын салбарын үйл ажиллагааг дэмжих, хүүхэд залуучуудад чанартай боловсролыг тэгш хүртээмжтэй олгох чиглэлээр 2016-2019 онд аймгийн ИТХ-ын тогтоол 11, бодлогын бичиг баримтын хэрэгжилтийг хянах зорилгоор 4 удаагийн хуралдааныг зохион байгуулж Боловсролын тухай хуулийн 29.1.2³-т заасан чиг үүргээ хэрэгжүүлж ажилласан байна.

Зураг № 2. Аймгийн ИТХ-ын хэрэгжүүлсэн арга хэмжээ /2016-2019 он/



Эх сурвалж: Аймгийн ИТХ-ын 2020.09.23-ны 2/76 тоот

2016-2019 оны хичээлийн жилд аймгийн хэмжээнд дундаж анги дүүргэлт 22.5 байсан нь БСШУС, НХХС-дын хамтарсан 2007 оны 307/91/237 тоот тушаалаар баталсан “Цэцэрлэг, ерөнхий боловсролын сургуулийн багшийн ажлын норм тогтоох, багш зарим албан тушаалтны цалин хөлсийг тооцож олгох журам”-ын 4⁴-т заасан нормтой нийцэж байна.

Гэвч аймгийн төвийн 1, 2, 3, 4, 5-р сургуулиуд, уул уурхай ихтэй Гурвантэс, Ханбогд, Цогтцэций сумдын сургуулийн зарим анги дүүргэлт 35-с хэтэрсэн бол бусад сумдын зарим анги дүүргэлт 18-д хүрэхгүй байгаа нь сурагчдын шилжилт хөдөлгөөн аймгийн төв, төвлөрөл ихтэй суурин газарт чиглэсэн байна.

³ Орон нутгийн өмчийн боловсролын байгууллагыг хөгжүүлэх төлөвлөгөө батлах, биелэлтэд хяналт тавих;

⁴ Анги дүүргэлтийг бага ангид 30-35 /багийн салбар бүлэгт 20-оос доошгүй/ дунд, ахлах ангид 32-35 ...;

Анги дүүргэлт 35-с хэтэрсэн

Анги дүүргэлт 18-д хүрээгүй

2016-2017 он

Сургууль нэр	Анги							
	1	2	3	4	5	6	9	11
Даланзадгад 1-р сургууль		41.5	40.8	41.5				
Даланзадгад 2-р сургууль	36.3	36.7					40	
Даланзадгад 3-р сургууль	44.4	37.2	42.5					36
Даланзадгад 4-р сургууль		38						
Гурвантэс сургууль			36.3					
Ханбогд сургууль	36	38.3	37		37	36		

2017-2018 он

Сургуулийн нэр	Анги							
	1	2	3	4	5	6	7	8
Даланзадгад 1-р сургууль	46		36.2	36.2	36.5			
Даланзадгад 2-р сургууль		48				46		
Даланзадгад 3-р сургууль	37.8	36						
Даланзадгад 4-р сургууль			35.7					
Даланзадгад 5-р сургууль			37.8	38				39.5
Гурвантэс сургууль				36				
Ханбогд сургууль		36.3	39.3	37		39	35.5	
Цогтцэций 1-р сургууль		36						
Цогтцэций 2-р сургууль	44	35.7						

2018-2019 он

Сургуулийн нэр	Анги									
	1	2	3	4	5	6	8	9	10	
Даланзадгад 1-р сургууль	43.6	47		35.5					36.5	
Даланзадгад 2-р сургууль	36.5				38.5	45	36			
Даланзадгад 3-р сургууль	37.8	36.5	36.5							
Даланзадгад 5-р сургууль	40.8			37.2	42			37		
Ханбогд сургууль		38.5	37.7	44.3	40	39	37			
Цогтцэций 1-р сургууль			37		37					
Цогтцэций 2-р сургууль	35.5	35.3	38.7							

Сургуулийн нэр	Анги									
	1	2	3	4	5	6	7	8	9	дундаж
Баян-Овоо					16			15		
Баяндалай		15	17					17	17.5	
Булган					14					
Мандал-Овоо					11	15		9		15.9
Манлай								17.5		
Номгон							14		15.5	
Ноён	17				16	7	15	13	12	15.3
Сэврэй		15.5		17				13	16	17.5
Ханхонгор	12	8			8	8				15.8
Хүрмэн				16	11	9	12	14		14.8
Цогт-Овоо			16							

Сургуулийн нэр	Анги									
	1	2	3	4	5	6	7	8	9	дундаж
Баян-Овоо						15			16	
Баяндалай			13.5	16					17.5	
Булган						13				
Мандал-Овоо				15		10	13		6	14.6
Манлай		17							16	
Номгон							17	14		
Ноён	15				16	13	8	11	12	14.2
Сэврэй	0	15	14		17		17		12	16.9
Ханхонгор	10		6			5	9	14	15	14.4
Хүрмэн	0	13			13	10	8	10	13	12.4
Цогт-Овоо		16			17					


Сургуулийн нэр	Анги									
	1	2	3	4	5	6	7	8	9	дундаж
Баян-Овоо							14			
Баяндалай	16									
Булган						16	13			
Мандал-Овоо	15				15		9	13		15.6
Номгон			17.5				17	16.5	13	
Ноён			12			13	8	4	9	13.4
Сэврэй				15				17		
Ханхонгор	12	10	13	6			7	10	16	13.7
Хүрмэн	15	12	16		17	11	10	7	10	12.1
Цогт-Овоо						17				

Эх сурвалж: БСУГ-ын статистик мэдээ /2017-2019 он/

2018-2019 оны хичээлийн жилд явуулсан БҮТ-ын чанарын үнэлгээний шалгалтаар сургуулиудын 9-р ангийн Математик, Монгол хэл, Физик, Англи хэлний хичээлийн чанарын дундаж үзүүлэлт, хүүхдийн тоо хоорондоо сул эерэг хамааралтай (хамаарлын коэффициент $\rho=0.48$), Даланзадгад сумын 2-р сургууль хамгийн өндөр 38.6%, Хүрмэн сумын сургууль хамгийн бага 16.1% үнэлгээтэй, хамгийн их, бага үнэлгээний зөрүү 22.5% байгаа нь сургуулиудын сургалтын чанар хүүхдийн шилжих хөдөлгөөнийг нэмэгдүүлэх шалтгааны нэг болж байна.

Иймд сумдын сургуулийн сургалтын чанарыг сайжруулж, тэгш хүртээмжтэй боловсрол олгох шаардлагатай байна.

Зураг № 3. Сургуулиудын чанарын дундаж үнэлгээ болон сурагчийн тооны хамаарал



Эх сурвалж: Аймгийн БСУГ-ын 2018-2019 оны чанарын үнэлгээний үр дүн тайлан

Хүснэгт № 6. 9-р ангийн чанарын үнэлгээний тойм статистик

Хэмжигдэхүүн	Тоон утга
Дундаж	26.8%
Далайц	22.5%
Хамгийн их утга	38.6%
Хамгийн бага утга	16.1%

Эх сурвалж: Аймгийн БСУГ-ын 2018-2019 оны чанарын үнэлгээний үр дүн тайлан

A.2.2 Боловсролын салбарт хийгдэж байгаа хөрөнгө оруулалтын захиалагчийн хяналтыг сайжруулах шаардлагатай байна.

Боловсрол олгоход шаардлагатай хэвийн, аюулгүй орчныг бүрдүүлэх зорилгоор Барилгын тухай хуулийн 11.1.1⁵-д заасан шаардлагуудыг хангахгүй болсон Манлай, Номгон, Ханбогд сумдын ЕБС-ийн хичээлийн байрыг шинээр барьж ашиглалтад оруулсан бол Даланзадгад, Хүрмэн, Цогтцэций суманд хичээлийн байрыг шинээр барьж байгуулж байна.

Зураг № 5. Номгон сумын ЕБС-ын шинэ барилга



Эх сурвалж: Аймгийн ОНХА

Зураг № 4. Манлай сумын ЕБС-ын шинэ барилга



Эх сурвалж: Аймгийн ОНХА

⁵ Механик аюулгүй байдлыг хангах: барилга байгууламжийн материал, хийц, бүтээц, эдлэхүүн нь барилгын ажлын болон ашиглалтын үед иргэдийн эрүүл мэнд, амь нас, эд хөрөнгө, хүрээлэн байгаа орчинд аюул учруулахгүй, бат бэх тогтвортой байх

Зураг № 7. Ханбогд сумын ЕБС-ийн шинэ барилга



Эх сурвалж: Аймгийн ОНХА

Зураг № 6. Даланзадгад сумын 1200 хүүхдийн шинэ ЕБС



Эх сурвалж: Аймгийн ОНХА

Сургалтын орчин, материаллаг байдлыг сайжруулах чиглэлээр 2017-2019 онд Улсын төсвөөс 11,536.7 сая төгрөг, орон нутгийн төсвөөс 8,898.5 сая төгрөг, “Говийн оюу” хөгжлийг дэмжих сангаас 8,291.5 сая төгрөгийн хөрөнгө оруулалт, БСШУЯ-аас 80.4 сая төгрөгийн техник тоног төхөөрөмжийг нийлүүлсэн байна.

Аудитаар ашиглалтын явцад дараах зөрчлүүд илэрлээ. Тухайлбал:

- ! 4-р сургуулийн Урлаг заалны барилгын халаалтын системийг бүрэн суулгаагүй, тайзны хөшиг тогтоох боломжгүй, цуурай ихтэй тул урлагийн тоглолт хийхэд хүндрэлтэй, дээврээс борооны ус дусдаг /Улсын төсвийн 1,056.4 сая төгрөг/
- ! 2014 онд БСШУЯ-аас аймгийн ЕБС-уудад нийлүүлсэн 80 ширхэг нийт 207.9 сая төгрөгийн Ухаалаг самбарыг ашиглахад удаан, удирдлагын функц дутуу ажилладаг, проектор дэлгэцийн хэлбэрээр ашигладаг
- ! “Англи хэлтэй - Өмнөговь” дэд хөтөлбөрийн хүрээнд тохижуулсан 49.5 сая төгрөгийн 2-р сургуулийн англи хэлний лингафоны танхимын удирдлагын функц нь ажилладаггүй.

Энэ нь хөрөнгө оруулалтын гүйцэтгэлийн явцад захиалагчийн хяналтыг хангалтгүй хийсэн, техник эдийн засгийн үзүүлэлтийг оновчгүй боловсруулснаас шалтгаалсан байна. Иймд дээрх зөрчлүүдийг дахин гаргахгүй байх Төсвийн тухай хуулийн 6.4.1⁶, Сангийн сайдын 2016 оны 415 дугаар тушаалаар батлагдсан “Төсвийн хөрөнгө оруулалтын төлөвлөлт, санхүүжилт, хяналт, тайлагналтын журам”-ын 5.1 дэх заалтуудыг тус тус хэрэгжүүлж ажиллах зөвлөмжийг хүргүүллээ.


А.2.3 Сумдын сургуулиудын багш нарын нэмэлт хичээлийг бууруулж, сурлагын чанарыг сайжруулах шаардлагатай байна.

2018-2019 оны хичээлийн жилд ЕБС-ын үндсэн орон тооны 12 хувийг сургуулийн захирал, менежер, нийгмийн ажилтан эзэлж байгаа бол 88 хувь нь үндсэн багш нар байна. Мөн үндсэн багш нарын 44 хувь аймгийн төвийн, 56 хувь нь сумдын сургуулиудад ажиллаж байна.

2016-2019 онуудад мэргэшлийн зэрэгтэй багш нарын тоо буурах хандлагатай байгаа бол бакалаврын зэргийн боловсролтой багш нарын тоо нэмэгдсэн байна.

⁶ Төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах

Зураг № 8. ЕБС-ын албан тушаал, орон тооны харьцаа



Эх сурвалж: Аймгийн БСУГ-ын 2018-2019 оны статистик мэдээ

Зураг № 9. 2016-2019 оны хичээлийн жилийн мэргэшлийн зэрэгтэй багш нарын тоо




Эх сурвалж: Аймгийн БСУГ-ын 2016-2019 оны статистик мэдээ

Зураг № 10. Багш нарын боловсролын зэрэг / 2016-2019 он/



Эх сурвалж: Аймгийн БСУГ-ын 2016-2019 оны статистик мэдээ

Зураг № 11. Багш нарын байршил аймгийн төв, сумдаар



Эх сурвалж: Аймгийн БСУГ-ын 2018-2019 оны статистик мэдээ

Сумын сургуулиудын бүлэг, хүүхдийн тоо багатайгаас нийт багш нарын 56 хувь нь сумдын 15 сургуульд багшилж, нэг багш ойролцоогоор 2-3 хичээлийг нэмэлтээр зааж байна.

Энэ нь БСШУС, НХХЯС-ын хамтарсан 2007 оны 307/91/237 тоот тушаалаар баталсан “Цэцэрлэг, ерөнхий боловсролын сургуулийн багшийн ажлын норм тогтоох, багш зарим албан тушаалтны цалин хөлсийг тооцож олгох журам”-ын 11⁷-т заасан хичээл заах нормт 19 цагийг хангаж байна.

⁷ Сургуулийн багш долоо хоногт 34 цагтай тэнцэх стандартыг хэрэгжүүлэх ажил, 6 цагтай тэнцэх бусад ажлыг тус тус гүйцэтгэнэ. Стандартыг хэрэгжүүлэх ажилд ногдох 34 цагийн 19 цаг нь хичээл заах цагт зориулагдана.

Хүснэгт № 7. Нэмэлт хичээл заадаг багш нарын судалгаа / 2016-2019 он/

№	Сургуулийн нэр	Нэмэлт хичээл зааг багийн тоо	Хичээлийн тоо	Нэг багшийн дундаж хичээл	Нэг багшийн дундаж цаг
1	Баяндалай сумын ЕБС	7	16	2.2	26.1
2	Номгон сумын ЕБС	5	14	2.8	22.4
3	Хүрмэн сумын ЕБС	7	18	2.5	20.8

Эх сурвалж: Аудитын талбарын ажлаар түүвэрлэв

2018-2019 онд хийсэн БҮТ-ийн чанарын судалгаагаар аймгийн төвийн болон сумдын сургуулийн сургалтын чанарын дунджийн зөрүү 6.3 хувь байгаа нь нэг багш нэмэлтээр мэргэжлийн бус хичээл заадаг нь сургалтын чанарт сөргөөр нөлөөлж байгаа тул сумдын сургуулийн багш нарын журамд заасан ажлын нормыг өөрчлөх, тэдгээрт тохирсон бодлого хэрэгжүүлж сургалтын чанарыг сайжруулах шаардлагатай байна.

А.3 ЕБС –ийн үдийн цайны төсөв хуваарилах зарчим, ном сурах бичиг түрээслэх үйл ажиллагааг зохицуулсан журмыг хэрэгцээ шаардлагад нийцүүлэн шинэчлэх шаардлагатай байна.

А.3.1 “Үдийн цай” хөтөлбөрийн нэг хүүхдэд ногдох зардлыг аймаг, сумын барааны бүтээгдэхүүний үнийн индекстэй уялдуулан төлөвлөх шаардлагатай байна.

Хүүхдийн илчлэг цай, хоолны зардал нэмэгдсэнээр хүүхдийн хоол, тэжээлийн суурь хэрэгцээнд дэмжлэг үзүүлэх, сурах нөхцөл боломжийг дэмжих, эрүүл мэнд, өсөлт бойжилтод нь эерэг нөлөө үзүүлэх ажлын хүрээнд аймгийн 21 сургууль “Үдийн цай хөтөлбөр”-т 2016 онд 560.7 сая, 2019 онд 608.7 сая төгрөг төлөвлөсөн нь хөтөлбөрийн зардлын хэмжээ 8.5 хувиар нэмэгдсэн байна.

ЗГ-ын 2019 оны Хоолны зардлын норматив тогтоох тухай” 450 дугаар тогтоолоор ЕБС-ийн бага ангийн сурагчдын “Үдийн цай”-ны зардал 600 төгрөгийг 900 төгрөг болгож нэмэгдүүлсэн ч БСШУС, ЭМС-дын хамтарсан 2006 оны 379/341 дүгээр тушаалын 2 дугаар хавсралтаар баталсан “Бага үд/үдийн дараах цайгаар авбал зохих хүнсний бүтээгдэхүүн, үндсэн шимт бодис ба илчлэгийн хэмжээ”-ний дагуу хүүхэд 340 ккал ичлэг авах бүтээгдэхүүний зардлыг хангахгүй байна.

Үүнээс шалтгаалан “Үдийн цай” хөтөлбөрийн бүтээгдэхүүний нийлүүлэх сонирхолтой аж ахуй нэгж байхгүй улмаас сургууль өөрсдийн гал тогоонд стандарт хангасан илчлэгтэй үдийн цай бэлтгэн сурагчдад олгож байгаа нь сургууль, дотуур байрны ажилчдын ажлын ачаалал нэмэгдүүлэх, гал тогооны шаардлагатай тоног төхөөрөмжийн дутагдал, хүнсний аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай дүрэм, журмыг зөрчих эрсдэл үүсэж байна.

Иймд “Үдийн цай” хөтөлбөрийн нэг хүүхдэд зарцуулагдах зардлыг тухайн сургуулийн байршил, бараа бүтээгдэхүүний үнийн индекстэй уялдуулан уян хатан нөхцөлтэй тогтоох шаардлагатай байна.

Хүснэгт № 8. Үдийн цай хөтөлбөрийн төсөв /2016-2019 он/

№	Сумын нэр	2016 он	2017 он	2018 он	2019 он
1	Баяндалай	13,749.0	18,000.0	13,258.0	11,548.2
2	Баян-овоо	11,040.0	9,502.0	12,340.2	12,863.9
3	Булган	10,656.0	10,600.0	10,382.0	9,156.0
4	Гурвантэс	45,162.4	21,938.8	38,967.0	43,480.0
5	Мандал-овоо	9,641.0	9,774.1	8,791.0	7,150.0
6	Манлай	16,986.2	12,000.0	18,387.8	18,000.0
7	Номгон	14,198.0	9,434.0	15,038.8	13,100.0
8	Ноён	11,223.0	10,967.5	9,300.0	7,100.0
9	Сэврэй	12,000.0	10,739.8	11,209.0	14,136.0
10	Ханбогд	45,965.0	20,838.0	86,076.0	30,316.5
11	Ханхонгор	9,000.0	12,438.0	9,427.3	5,980.0
12	Хүрмэн	7,797.0	12,362.1	6,590.0	7,140.0
13	Цогт-овоо	10,500.0	10,627.0	8,027.0	13,139.3
14	Цогтцэций 1-р сургууль	38,390.0	20,162.0	12,099.0	47,564.3
15	Цогтцэций 6-р сургууль	45,800.4	23,300.0	39,705.0	66,282.6
16	Даланзадгад 1-р сургууль	77,336.5	38,841.6	44,333.0	81,400.0
17	Даланзадгад 2-р сургууль	37,797.1	17,898.9	81,537.0	32,968.0
18	Даланзадгад 3-р сургууль	75,950.2	27,402.0	27,507.0	65,020.0
19	Даланзадгад 4-р сургууль	43,348.2	26,228.2	63,017.3	43,360.0
20	Даланзадгад 5-р сургууль	24,192.0	19,152.2	45,070.0	79,000.0
21	Даланзадгад 7-р сургууль			71,800.0	
	Нийт	560,732.0	342,206.2	632,862.4	608,704.8

Эх сурвалж: Аймгийн БСУГ-ын төсвийн нэгтгэл / 2016-2019/

Зураг № 12. Даланзадгад сумын 5-р сургуулийн үдийн цайны цэс

БАТЛАВ: ӨМНӨГОВЬ АЙМАГ
ДАЛАНЗАДГАД СУМЫН 5-СУРГУУЛЬ
ЗАХИРАЛ: Г.ШҮРЦЭЦЭГ

2020 ОНЫ 10- САРЫН 5 НААС 10- САРЫН 9 НИЙ ХООЛНЫ ЦЭС

1-Р 7 ХОНОГ

Д/Д	ӨДӨР	ХООЛНЫ НЭР	ХЭМЖЭЭ	ШИМТ БОДИС ГР-ААР ИЛЧЛЭГ			
				УУРАГ	ТОС	НҮҮРС У С	ККАЛ
1	ДАВАА	СҮҮТЭЙ БУДАА	150	6.1	6.8	18.3	330
2	МЯГМАР	ГОЙМОНТОЙ ХУУРГА	150	5.28	5.6	7.68	368.5
		СҮҮТЭЙ ЦАЙ	100				
3	ЛХАГВА	БИНТЭЙ ШӨЛ	150	17.23	17.96	34.11	449.6
		ЦУЙВАН	150	8.11	4.13	105.9	387
4	ПҮРЭВ	СҮҮТЭЙ ЦАЙ	100				
5	БААСАН	ШАР БУДААТАЙ ШӨЛ	150	6.8	3.3	18.2	332.2

ЦЭС ГАРГАСАН ТОГООЧ *Н. Мамуяга*-н мөнхцэцэг

Эх сурвалж: 5-р сургуулийн үйл ажиллагааны тайлан

А.3.2 Сурагчдад сурах бичгийг түрээсээр олгох журмыг хэрэгцээ шаардлагад нийцүүлэн шинэчлэн батлах шаардлагатай байна.

БСШУСС-дын 2019 оны А/302 тоот тушаалаар батлагдсан “Ерөнхий боловсролын сургуулийн суралцагчдад сурах бичиг төлбөртэй ашиглуулах үйлчилгээний журам”-ын дагуу дунд, ахлах ангийн сурагчдад сургуулийн номын сангаар дамжуулан тухайн хичээлийн жилд сурах бичгийг БСШУСС-ын 2019 оны “Төлбөрийн хэмжээ тогтоох тухай” А/624 дугаар тушаалын 1 дүгээр хавсралтаар тогтоосон төлбөрийн нөхцөлийн дагуу олгож байна.

ЕБС-иудын номын сан 2019 онд 3860 багц 73.1 сая төгрөгийн түрээсийн сурах бичиг хүлээн авснаас 26 хувь буюу 19.7 сая төгрөгийн сурах бичгийг

сурагчдад түрээслүүлэн сурах бичгийг түрээсийн үйлчилгээ хангалтгүй хэрэгжсэн нь дараах шалтгаанаас үүсэн байна. Үүнд:

- ! COVID-19 цар тахлын улмаас ЕБС-иудад хорио цээрийн дэглэм тогтоосон,
- ! БСШУСС-дын 2019 оны А/302 тоот тушаалаар батлагдсан “Ерөнхий боловсролын сургуулийн сурагчдад сурах бичиг төлбөртэй ашиглуулах үйлчилгээний журам”-ын 1.3.3⁸, БСШУСС-ын 2019 оны “Төлбөрийн хэмжээ тогтоох тухай” А/624 дүгээр тушаалын 1 дүгээр хавсралт нь сурагч сонгон судлаагүй хичээлийн сурах бичгийг авахгүй байх, эсвэл шаардлагатай хичээлийн сурах бичгээ түүвэрлэн сонгох, номын сангийн уншлагын танхимаар ашиглах зэрэг боломжийг хязгаарлаж байна.

Иймд сурагч өөрийн сонголтоор ном сурах бичгийг түрээслэх боломжийг олгох зохицуулалтай болгож дээрх 2 тушаалыг хэрэгцээ шаардлагад нийцүүлэн шинэчлэн батлах шаардлагатай байна

Хүснэгт № 9. Түрээсийн сурах бичгийн олголт

№	Сумын нэр	Бүлэг 6-12	Хүлээж авсан сурах бичиг	Төлбөртэй ашиглуулж байгаа	Үлдсэн сурах бичиг
1	Баяндалай сумын сургууль	7	89	21	68
2	Баян-овоо сумын сургууль	4	35	7	28
3	Булган сумын сургууль	4	42	14	28
4	Гурвантэс сумын сургууль	7	293	64	229
5	Мандал-овоо сумын сургууль	4	36	25	11
6	Манлай сумын сургууль	4	80	8	72
7	Номгон сумын сургууль	4	49	49	0
8	Ноён сумын сургууль	4	28	28	0
9	Сэврэй сумын сургууль	4	45	37	8
10	Ханбогд сумын сургууль	7	151	88	63
11	Ханбогд сумын сургууль	6	154	109	45
12	Ханхонгор сумын сургууль	7	47	36	11
13	Хүрмэн сумын сургууль	4	17	16	1
14	Цогт-овоо сумын сургууль	4	61	25	36
15	Цогтцэций 1-р сургууль	7	334	60	274
16	Цогтцэций 6-р сургууль	7	264	77	187
17	Даланзадгад 1-р сургууль	7	636	110	526
18	Даланзадгад 2-р сургууль	7	212	66	146
19	Даланзадгад 3-р сургууль	7	376	38	338
20	Даланзадгад 4-р сургууль	7	363	58	305
21	Даланзадгад 5-р сургууль	7	402	53	349
22	Даланзадгад 7-р сургууль	7	146	48	98
НИЙТ			3860	1037	2823

Эх сурвалж: Аймгийн БСУГ-ын сурах бичгийн статистик мэдээ

⁸ “сурах бичиг ашиглах төлбөр” гэж суралцагч суралцах ангийнхаа бүх /багц/ сурах бичгийг хичээлийн жилийн турш ашиглахтай холбогдох төлбөр

БҮЛЭГ 2

ЕБС-удын дотоод хөндлөнгийн хяналт хийх арга зүйг сайжруулж, тэгш хүртээмжтэй бодлого хэрэгжүүлэх шаардлагатай байна.

Б.1 Ерөнхий боловсрол олгох хөтөлбөрийг тэгш хүртээмжтэй хүргэж, сурагчдын үр дүнгийн үнэлгээг бодитой хийх шаардлагатай байна.

Б.1.1 Аймгийн дэд хөтөлбөрийн хэрэгжилт сургууль, суурь, бүрэн дунд боловсролын агуулгад харилцан адилгүй байна.

Аймгийн ЗДҮАХ /2016-2020/-ийн дагуу математикийн хичээлийн сургалтыг сайжруулах “Оюуны хурд”, Англи хэлний сургалтыг сайжруулах “Англи хэлтэй - Өмнөговь” хөтөлбөрийг 2017 оноос эхлэн аймгийн 21 сургуульд хэрэгжүүлсэн байна.

Аудитаар 17 сургуулийн 2016-2017 оны хичээлийн 7-р ангийн 28 бүлгийн зорилтод хөтөлбөр хэрэгжүүлсэн математик, англи хэлний хичээлийг, нийгмийн ухааны хичээлийн 2016-2019 оны хичээлийн жилийн сурлагын үр дүнгийн үнэлгээний өсөлтийг харьцуулахад математик, англи хэлний хичээл 1 хувиар буурсан бол нийгмийн ухааны хичээл 1 хувиар өссөн үзүүлэлтэй байна.

Хүснэгт № 10. Сурагчдын үр дүнгийн үнэлгээний өсөлт, бууралт (2016-2019 он)

№	Сургуулийн нэр	Математик (%)	Англи хэл (%)	Нийгмийн ухаан (%)
1	1-р сургууль	+2	-1	0
2	2-р сургууль	+2	-9	+3
3	3-р сургууль	-9	-9	-8
4	4-р сургууль	-5	0	-6
5	5-р сургууль	+6	+3	+2
6	7-р сургууль	-6	-3	-2
7	Баяндалай	+1	+1	+3
8	Баян-Овоо	0	0	0
9	Булган	+2	+2	+1
10	Гурвантэс	+2	+8	+5
11	Номгон	+5	-1	+3
12	Сэврэй	+1	+1	+3
13	Ханхонгор	-22	-2	-3
14	Хүрмэн	0	+2	+7
15	Цогт-Овоо	+3	+1	+3
16	Цогтцэций 1-р сургууль	-1	-2	0
17	Цогтцэций 2-р сургууль	0	+2	-2
ДҮН		-1%	-1%	+1%

Эх сурвалж: Аудитаар сургуулиудад хийсэн сурагчдын үр дүнгийн үнэлгээний судалгаа

Ханхонгор сумын сургуулийн математикийн хичээл үнэлгээ 22 хувиар, Даланзадгад сумын 3-р сургуулийн математик 9 хувиар, англи хэл 9 хувиар, нийгмийн ухаан 8 хувиар буурсан нь сурлагын хоцрогдол үүссэн нь хөтөлбөр үр дүнд хүрээгүйг харуулж байна.

Математикийн хичээлийн үнэлгээнд 8 сургууль, англи хэлний үнэлгээг 9 сургуульд ахиц гараагүй байгаа нь “Оюуны хурд”, “Англи хэлтэй - Өмнөговь” хөтөлбөрүүд сургуулиудад харилцан адилгүй хэрэгжсэнийг харуулж байна.

ЭЕШ-д бэлдэх ажлыг аймгийн Засаг даргын албан даалгаврын дагуу БСУГ-аас зохион байгуулсан тандах шалгалтын үр дүнд суурилсан зөвлөмж боловсруулан шалгалтад бэлдэж ажилласан байна.

Үүний үр дүнд аймгийн ЭЕШ-ын дундаж хэмжээст оноо 2018-2020 онд өссөн, дундаж оноогоор улсын хэмжээнд дээгүүр байр эзэлсэн үзүүлэлтэй байна.

Хүснэгт № 11. Өмнөговь аймгийн ЭЕШ-ын дүн /2017-2020 он/

№	Хичээлийн нэр	Хэмжээст оноо											
		2017			2018			2019			2020		
		Аймгийн дундаж	Улсын дундаж	Эзэлсэн байр	Аймгийн дундаж	Улсын дундаж	Эзэлсэн байр	Аймгийн дундаж	Улсын дундаж	Эзэлсэн байр	Аймгийн дундаж	Улсын дундаж	Эзэлсэн байр
1	Математик	488	498	19	483	498	47	513	50	6	519	500	4
2	Англи хэл	473	483	15	466	483	19	517	500	1	495	500	7
3	Нийгмийн ухаан	511	499	4	486	507	21	511	500	10	541	500	2

Эх сурвалж: Аймгийн БСУГ-ын статистик судалгаа

Зорилтод хөтөлбөрүүд Боловсролын тухай хуулийн 5.1.1-д заасан суурь боловсролын агуулгыг бүрэн сургах, чадвар эзэмшүүлэхэд бага, харин ЭЕШ-д амжилт гаргах, богино хугацаанд үр дүн үзүүлэх зорилтод чиглэсэн байна.


Иймд цаашид бага, суурь, бүрэн дунд боловсролыг олгох зорилтод хөтөлбөрийг тэгш хүртээмжтэй хэрэгжүүлэх, бодлого хөтөлбөрийн хүрэх үр дүн, үзүүлэх нөлөөг урт, богино хугацаанд тооцож төлөвлөх, бодлогын хэрэгжилтийг үе шат бүрд үнэлэх шаардлагатай байна.

Б.1.2 Сурагчдын үр дүнгийн үнэлгээнд баримтлах зарчмыг барьж ажиллах шаардлагатай байна.

2018-2019 оны хичээлийн жилд БҮТ-өөс чанарын үнэлгээний шалгалтыг аймгийн 21 сургуулийн 9-р ангийн давхардсан тоогоор 20682 сурагчдаас математик, монгол хэл, физик, англи хэлний хичээлээр явуулсан байна.

Уг шалгалтаар улсын дунджаас математик 11.5 хувиар, монгол хэл 0.1 хувиар, физик 2.9 хувиар, англи хэл 9.4 хувиар тус тус доогуур үнэлэгдсэнийг сургуулийн сургалтын бодлогыг тодорхойлохдоо эдгээр хичээлүүдийн гүйцэтгэлийн хувийг ахиулах ажлыг сургууль бүрд анхаарч ажиллахыг зөвлөсөн байна.

Зураг № 13. 2018-2019 оны хичээлийн жилийн чанарын үнэлгээ /9-р анги/




Эх сурвалж: БСУГ газрын 2018-2019 оны чанарын үнэлгээний үр дүн тайлан

Аймгийн БСУГ дээрх чанарын үнэлгээний дагуу хичээл бүрээр дүгнэлт хийж сургалтын чанарын үнэлгээг сайжруулах чиглэлээр зөвлөмж гаргасан ч сургуулиуд зөвлөмжийг хэрэгжүүлэх арга хэмжээ зохион байгуулан, түүний ахиц үр дүнг тооцож баталгаажуулаагүй байна.

Аудитын явцад сургуулиудын 2018-2019 оны хичээлийн жилийн 9-р ангийн математик, англи хэлний хичээлийн сурагчдын үр дүнгийн үнэлгээг БҮТ-ын хөндлөнгийн шалгалтын дүнтэй харьцуулж үзлээ.

Баяндалай сумын сургууль хамгийн их буюу 70.5 хувиар, Ханхонгор сумын сургууль хамгийн бага буюу 43.6 хувиар зөрүүтэй үнэлсэн, үнэлгээ хоорондын хамаарал маш бага (хамаарлын коэффициент $\rho=0.33$) байгаа нь багш нар сурагчдын дүнг өсгөж дүгнэдгийг харуулж байна.

Зураг № 14. БҮТ болон сурагчдын үр дүнгийн үнэлгээний зөрүү /2018-2019 оны хичээлийн жил/



Эх сурвалж: Аудитаар хийсэн судалгаа болон БСУГ-ын 2019 оны чанарын үнэлгээний тайлан

Энэ нь БСШУС-ын 2018 оны А/425 дугаар тушаалаар батлагдсан “Ерөнхий боловсролын сургуулийн суралцагчийн болон сургалтын чанарын үнэлгээний журам”-ын 2.1⁹, 2.2¹⁰-т заасан үнэлгээнд баримтлах зарчмыг алдагдуулсан тул үнэлгээ хийж буй багш нар дээрх зарчмыг баримталж ажиллах шаардлагатай байна.

Б.2 ЕБС-удад хийх доотоод хөндлөнгийн үнэлгээ, хяналт шинжилгээ хийх арга зүйг сайжруулах шаардлагатай байна.

Б.2.1 БСУГ болон ЕБС дотооддоо сурлагын хөндлөнгийн үнэлгээ хийх, түүний дагуу арга хэмжээ зохион байгуулж үр дүнг тооцох аргачлал боловсруулах шаардлагатай байна.

Ерөнхий боловсрол олгох хөтөлбөрийн хэрэгжилтэд хийх хөндлөнгийн үнэлгээний шалгалтыг БҮТ-өөс 2018-2019 оны хичээлийн жилд 21 сургуулийн 9-р анги болон түүврээр сонгогдсон Даланзадгад сумын 1, 5 дугаар сургууль, Баяндалай сумын 5, 9, 12-р ангиудыг хамруулан гүйцэтгэсэн байна.

Мөн аймгийн БСУГ-аас 2019 оны 03 дугаар сард гурван сургуулийн 9-р ангиудын дунд хөндлөнгийн түвшин тогтоох шалгалтыг зохион байгуулж ажилласан байна.

Аймгийн БСУГ, ЕБС-ийн түвшинд хөндлөнгийн чанарын үнэлгээ хийх нэгдсэн арга зүй, удирдлагын бичиг баримт байхгүйгээс дээрх шалгалтын дагуу сургалтын чанарыг сайжруулах талаар хэрэгжүүлсэн ажил арга хэмжээ тодорхойгүй, хүрсэн үр дүн, харьцуулсан судалгаа шинжилгээ хийгээгүй нь сургалтын хөтөлбөрт тавигдах шат шатны хяналтын үр нөлөөг бууруулсан байна.

Иймд хөндлөнгийн шалгалтын үр дүнд суурилсан сургалтын хөтөлбөрийг сайжруулах арга хэмжээг хэрэгжүүлж, дараагийн шатны үнэлгээгээр гарсан үр дүнг харьцуулж дүн шинжилгээ хийх зэрэг хөндлөнгийн үнэлгээний арга зүйг боловсруулж, “Төрөөс боловсролын талаар баримтлах бодлого”-ын 3.18¹¹ дахь заалтыг хэрэгжүүлж ажиллах шаардлагатай байна.

Б.2.2 ЕБС сургуулийн үйл ажиллагаанд тавих хяналтыг хэрэгжүүлж, эцэг эх, олон нийтийн оролцоог хангахад анхаарч ажиллаж байна.

Аймгийн МХГ-ын 2018 оны 16/09/56/166 дугаартай улсын байцаагчийн дүгнэлтээр Боловсролын хяналтын улсын байцаагч, Эрүүл ахуй, халдвар хамгааллын хяналтын улсын байцаагчийн хамтран явуулсан Боловсролын байгууллагад хийсэн төлөвлөгөөт шалгалтын үр дүнг аймгийн Засаг даргад хүргүүлсэн байна.

⁹ Үнэлгээ нь шударга, бодитой, хөндлөнгийн нөлөөллөөс ангид, шалгуурт суурилсан, суралцагчийн сурах хүсэл эрмэлзэл, сонирхол, ур чадвар, ахиц, амжилтыг дэмжсэн, урамшуулах, хөгжүүлэхэд чиглэсэн байх;

¹⁰ Үнэлж дүгнэх үйл ажиллагаа нь зорилготой, сургалтын хөтөлбөрт нийцсэн, суралцагчийн нас, сэтгэхүй, хөгжлийн ялгаатай байдал, онцлог хэрэгцээг харгалзсан, агуулга, хэлбэр нь уян хатан, багш, суралцагч, эцэг эх, асран хамгаалагчид ойлгомжтой, нээлттэй, ил тод байх;

¹¹ Бүх шатны боловсролын байгууллагын үйл ажиллагаанд өөрийн үнэлгээ, дотоод мониторингийн тогтолцоог хөгжүүлнэ

Дээрх төлөвлөгөөт шалгалтаар ЕБС-тай холбоотой Боловсролын тухай хууль, Бага, дунд боловсролын тухай хууль, Засгийн газрын тогтоол, БСШУС-ын тушаал болон бусад захиргааны акт зөрчсөн 13 зөрчлийг илрүүлж, зөрчил арилгах тухай саналыг хүргүүлж ажилласан байна.

Сургуулийн орчинд гэмт хэргээс урьдчилан сэргийлэх зорилгоор Цагдаагийн газар, ГХУСАЗЗ-өөс хамтран “School Police” хөтөлбөрийг аймгийн хэмжээнд эцэг эх, олон нийтийн оролцоотой зохион байгуулж байна.

Мөн аймгийн БУСГ болон ЕБС-иуд үйл ажиллагааны төлөвлөгөөнд эцэг эх, олон нийтийн оролцоог нэмэгдүүлэх зорилгоор арга хэмжээнүүдийг төлөвлөж хэрэгжүүлж байгаагаас доорх арга хэмжээнүүд сайн жишээ болж байна. Үүнд:

- ✓ Аймгийн БСУГ-аас ЭЕШ-т бэлдэж байгаа хүүхдийн зан төлөвийг судалж хүүхдийн эцэг эхчүүдэд суралцах бэлдэх арга барил, ирээдүйн мэргэжлээ сонгох чиг баримжааг олгох,
- ✓ Даланзадгад сумын 1-р сургуулийн 1-5 дугаар ангийн сурагчдыг хичээлд ирэх цагт эцэг эх, асран хамгаалагчаас хүлээн авч, тарахад хүлээлгэн өгөх “Гараас гарт” арга хэмжээ,
- ✓ Даланзадгад сумын 5-р сургуулийн нийгмийн ажилтан сурагчдын зан байдлыг анги удирдсан багштай хамтран асуумжаар судалж эцэг эхэд нь мэдэгдэж хүүхэд хөгжүүлэх чиглэлд анхаарах,
- ✓ Хүрмэн сумын ЕБС жил бүр эцэг эхийн нээлттэй хаалганы өдөрлөг зохион байгуулж санал асуулгаар хүүхэд хөгжүүлэх шаардлагатай байгаа асуудлуудыг хамтран шийддэг,
- ✓ Цогтцэций сумын 2-р сургууль Good neighbors олон улсын байгууллагатай хамтран багш, эцэг эх, сурагчдад багшийн хөгжил, хүүхэд хамгааллын чиглэлээр сургалт зохион байгуулах,

Цаашид дээрх ажлуудыг зохион байгуулалтын хэлбэрийг сайжруулах, үр дүнг судалгаагаар тогтоож аймгийн хэмжээнд жишиг болгон хэрэгжүүлэхээр байна.

Зураг № 16. “School police” хөтөлбөрийн үйл ажиллагаа



Эх сурвалж: Аймгийн ОНХА

Зураг № 15. “School police” хөтөлбөрийн үйл ажиллагаа



Эх сурвалж: Аймгийн ОНХА

ДҮГНЭЛТ

Аудитын явцад цуглуулсан нотлох зүйл, аудитын дүнд үндэслэн дараах дүгнэлтийг хийж байна. Үүнд:

- ✓ Сумдын сургуулийн бүтэц орон тооны хязгаарлагдмал байдал, сурагч, бүлгийн тооноос хамаарч дунд ангийн багш нар хичээл заах нормт цагаа гүйцээхийн тулд мэргэжлийн бус хичээл заадаг нь сургалтын хоцрогдол үүсэх, улмаар сурагчдын шилжилт хөдөлгөөн ихсэх шалтгааны нэг болж байна.
- ✓ Багш боловсон хүчний хүрэлцээ, тэдгээрийн ажиллах горимоос шалтгаалсан аймгийн төвийн болон сумдын сургуулийн хооронд сургалтын чанарын ялгаа гарсаар байна.
- ✓ Улс, орон нутгийн төсвийн хөрөнгөөс сургуулийн орчин нөхцөлийг сайжруулах хөрөнгө оруулалт хийж байгаа ч зарим төсөл арга хэмжээнд захиалагчийн хяналт хангалтгүй хийх, техникийн хэрэгцээ шаардлага хангахгүй техник тоног төхөөрөмж нийлүүлэгдсээр байна.
- ✓ “Үдийн цай” хөтөлбөрийн нэг хүүхдэд ногдох зардлыг алслагдмал сумдын сургуульд барааны үнийн индексээс шалтгаалан нормт заасан илчлэг хангах бүтээгдэхүүн нийлүүлэхэд хүрэлцэхгүй байна.
- ✓ Сурагч өөрийн шаардлагатай сурах бичгийг багцаас салгаж түрээслэх боломжгүй байгаа нь түрээсийн сурах бичгээр сурагчдыг хангах ажлын хэрэгжилт хангалтгүй байна.
- ✓ БҮТ-ийн чанарын хяналт, сурагчдын үр дүнгийн үнэлгээний харилцан хамааралгүй үнэлэгдэж байгаа нь багш нар сурагчдын үр дүнгийн үнэлгээг шударга, бодитой, шалгуурт суурилсан байх зарчимд нийцэхгүй байгааг харуулж байна.
- ✓ ЕБС-дад сургалтын чанарын дотоод хөндлөнгийн үнэлгээг өөр, өөр арга зүйгээр хийж байгаа нь сургалтын чанарт нөлөөж буй хүчин зүйл, тэдгээрийг арилгах арга замыг оновчтой тодорхойлох боломжийг хязгаарлаж сургалтын чанарт сөргөөр нөлөөлж байна.
- ✓ Аймгийн “Англи хэлтэй - Өмнөговь”, “Оюуны хурд” дэд хөтөлбөрүүд сургууль, дунд, ахлах ангийн сурагчдын дунд харилцан адилгүй хэрэгжиж, сумдын сургууль, дунд ангийн бүлгийн сурагчдын дунд сурлагын хоцрогдол, анги дэвших бүрд сурлагын үнэлгээ муудах хандлага гарсан байна.

ЗӨВЛӨМЖ

Аудитаар илрүүлсэн зүйл, дүгнэлтэд үндэслэн сурлагын чанар, хүртээмжийг сайжруулах чиглэлээр дараах арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг зөвлөж байна. Үүнд:

Аймгийн Засаг даргад:

- ✓ Сумдын сургуулийн багш нарыг мэргэжлийн хичээлээ заах, дутагдалтай хүний нөөцийг бүрдүүлэх, тэдгээрийн цалин хөлс урамшууллыг сургалтын амжилттай уялдуулан тооцох хөтөлбөр, төлөвлөгөө боловсруулан аймгийн төв болон сумдын сургуулийн сурлагын чанарын ялгааг арилгахад бодлого боловсруулж ажиллах
- ✓ Боловсролын салбарт хэрэгжүүлэх хөтөлбөр зорилтыг төв суурийн газар болон боловсролын түвшинд тэгш хүртээмжтэй, суурь болон хүрэх түвшнийг оновчтой тодорхойлох, хөтөлбөрийн нөлөөллийг урт богино хугацаанд ангилан тооцож боловсруулах,

Аймгийн БСУГ-т:

- ✓ Аймгийн хэмжээнд ЕБС дотооддоо болон БСУГ-аас хийх хөндлөнгийн түвшин тогтоох шалгалт хийх арга зүйг боловсруулан үр дүнг тооцдог байх,
- ✓ Боловсролын салбарт хийгдэж буй хөрөнгө оруулалтын гүйцэтгэлд хяналт тавьж ажиллах,
- ✓ Багш нарын сурагчдын үр дүнгийн үнэлгээг шударга, бодитой, шалгуурт суурилсан үнэлгээ хийхэд хяналт тавьж ажиллах,

ЕБС-иудад:

- ✓ Дотоод хяналт шинжилгээ, сурлагын чанарын хөндлөнгийн үнэлгээнд хийх хяналтыг судалгааны арга зүйд суурилсан, үр дүнтэй зохион байгуулах,
- ✓ Байгууллагын үйл ажиллагааны хөтөлбөр төлөвлөгөөг сурлагын чанарт нөлөөлж буй хүчин зүйлсийг бууруулах чиглэлд судалгаанд суурилан төлөвлөх,
- ✓ Боловсролын тухай хуулийн 35.1¹²-д заасны дагуу Гурвантэс, Номгон сумдад сургуулийн зөвлөл байгуулах,

¹² Сургууль, цэцэрлэгийн зөвлөл нь багш, ажилтан, сурагч, эцэг, эх бусад байгууллагын төлөөлөлтэй байна. 9-11 гишүүнтэй сургууль, цэцэрлэгийн зөвлөлийг 3 жилийн хугацаагаар сонгоно

ДЭЭД ШАТНЫ БАЙГУУЛЛАГАД ХҮРГҮҮЛЭХ САНАЛ

Аудитаар илрүүлсэн зүйл, дүгнэлтэд үндэслэн дараах саналыг YAГ-т хүргүүлж байна. Үүнд:

✓ БСШУС, НХХЯС-дын хамтарсан 2007 оны 307/91/237 тоот тушаалаар баталсан “Цэцэрлэг, ерөнхий боловсролын сургуулийн багшийн ажлын норм тогтоох, багш зарим албан тушаалтны цалин хөлсийг тооцож олгох журам”-ын 11-д “*Сургуулийн багш долоо хоногт 34 цагтай тэнцэх стандартыг хэрэгжүүлэх ажил, 6 цагтай тэнцэх бусад ажлыг тус тус гүйцэтгэнэ. Стандартыг хэрэгжүүлэх ажилд ногдох 34 цагийн 19 цаг нь хичээл заах цагт зориулагдана*” гэж заасан 19 цагийг сумдын сургуулийн нөхцөл байдалд нийцүүлэн өөрчлөх,

✓ БСШУС-ын 2018 оны А/425 дугаар тушаалаар батлагдсан “Ерөнхий боловсролын сургуулийн суралцагчийн болон сургалтын чанарын үнэлгээний журам”-ын 6 дугаар бүлэгт заасан чанарын үнэлгээ зохион байгуулалтын хэсэгт чанарын үнэлгээний ул мөрөөр сурлагын чанар сайжруулах ажил арга хэмжээг зохион байгуулах, түүний үр дүнг тооцох хэсгийг нэмэлтээр оруулах зөвлөмжийг Боловсрол, шинжлэх ухааны яаманд хүргүүлэх,

✓ ЕБС-ийн бага ангийн сурагчдын “Үдийн цай”-ны зардлыг тухайн аймаг, сумын бараа бүтээгдэхүүний үнийн индекс, БСШУС, ЭМС-дын хамтарсан 2006 оны 379/341 дүгээр тушаалын 2 дугаар хавсралтаар баталсан “Бага үд/үдийн дараах цайгаар авбал зохих хүнсний бүтээгдэхүүн, үндсэн шимт бодис ба илчлэгийн хэмжээ”-тэй уялдуулан шинэчлэх,

✓ БСШУСС-дын 2019 оны А/302 тоот тушаалаар батлагдсан “Ерөнхий боловсролын сургуулийн суралцагчдад сурах бичиг төлбөртэй ашиглуулах үйлчилгээний журам”, БСШУСС-ын 2019 оны “Төлбөрийн хэмжээ тогтоох тухай” А/624 дугаар тушаалын 1 дүгээр хавсралтыг сурагч өөрийн сонгосон хичээлийн номыг сонгож авах, номын сангийн уншлагын танхимаар дамжуулан авах боломжтой болгож өөрчлөх,

ТАЙЛАН БОЛОВСРУУЛСАН:

АУДИТОР

Ш.ОТГОНБАЯР

Ч.НАРАНБАДРАХ

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОРЫН ТУШААЛ



ӨМНӨГОВЬ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗРЫН ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОРЫН ТУШААЛ

2020 оны 10 сарын 30 өдөр

Дугаар А/32

Даланзадгад сум

Аудитын тайлан баталгаажуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1 дэх заалт, 9 дүгээр зүйл, Монгол Улсын Ерөнхий аудиторов 2018 оны А/207 дугаар тушаалын тавдугаар хавсралтын 1.3 дахь заалт, 2016 оны А/92 дугаар тушаалаар батлагдсан “Гүйцэтгэлийн аудитын журам”-ын 12.40 дэх заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. “Төрөөс бүх нийтийн боловсрол олгож буй өнөөгийн байдал, үр дүн”-д хийсэн гүйцэтгэлийн аудитын тайланг баталсугай.
2. Аудитын тайланг аймгийн Засаг даргын орлогч /С.Мөнхбаяр/- д, Боловсрол соёл урлагийн газрын дарга /Г.Бат-эрдэнэ/-д тус тус хүргүүлсүгэй.
3. Аудитаар өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлэх арга хэмжээ авч, үр дүнг 2021 оны 2 дугаар улиралд Өмнөговь аймаг дахь Төрийн аудитын газарт ирүүлэхийг аймгийн Засаг даргын орлогч /С.Мөнхбаяр/-д, Боловсрол соёл урлагийн газрын дарга /Г.Бат-Эрдэнэ/-д зөвлөсүгэй.
4. Зөвлөмжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг хэлтсийн дарга бөгөөд аудитын менежерийн албан үүргийг түр орлон гүйцэтгэгч /С.Одончимэгт/-д даалгасугай.
5. Аудиттай холбоотой ажлын болон нотлох баримтыг тайлан баталгаажуулснаас хойш 14 хоногийн дотор архивын нэгж болгон хүлээлгэн өгөх, аудитын тайланг хэвлэл мэдээллийн хэрэгсэл, олон нийтэд түгээхийг гүйцэтгэлийн аудитын баг /Ч.Наранбадрах/-т үүрэг болгосугай.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОРЫН
АЛБАН ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН
ГҮЙЦЭТГЭГЧ



Т.ХОНГОРЗУЛ

D:\Бичиг Хэрэг\А Тушаал 2020\А-32.Docx

000010038